



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/552

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.3.5, 3.4.5 дахь хэсэг, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн багш нар, төрийн албан хаагчдыг мэргэжил ур чадварыг дээшлүүлж чадавхжуулах "Уран бичлэг"-ийн танхимын сургалт, "Үндэсний бичиг, өв соёл-Алтайн бахархал" уралдаан зохион байгуулах арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Боловсролын газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201301911

Аймгийн засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/55 дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт



"Уран бичлэг"-ийн танхимын сургалтын төсвийн зардлын тооцоо

		Тоо ширхэг	Мөнгөн дүн	Нийт дүн
1.	Сургалтын хэрэгсэл	30 хүн	50000	1.500.000
2.	Замын зардал, буудал хоол	2 багш	400000	800.000
3.	Багшийн цалин	2 багш	700.000	1.400.000
4.	Бичиг хэргийн болон үзэсгэлэнгийн тайлангийн зардал		300000	
5.	Нийт		4.000.000	

"Үндэсний бичиг, өв соёл-Алтайн бахархал"  
уралдааны шагналын зардлын тооцоо

№	Байр	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Нэгдүгээр байр	4 хүн	2.800.000
2	Хоёрдугаар байр	4 хүн	2.000.000
3	Гуравдугаар байр	4 хүн	1.600.000
4	Тусгай байр	8 хүн	1.600.000
	Нийт		8.000.000

\_\_оОо\_\_